



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 183

Номгон

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний  
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

ДАРГА



Э. ЭНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 21-ний  
өдрийн 123 дугаар тогтоолын хавсралт



“БАЯНХОНГОР-ЭРЧИМ ХҮЧ” ЦТХХК-НИЙ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН БҮРЭЛДЭХҮҮН

- Д.Батжаргал-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
- Д.Ууганцэцэг-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
- Д.Батболд-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
- Ж.Дулмаа-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
- Ж.Хүрэлбаатар-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
- Л.Доржханд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
- С.Батцэрэн-Иргэний төлөөлөл
- ~~И~~ Дорж -Иргэний төлөөлөл
- Б.Баттогтох-Иргэний төлөөлөл



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 39


Номгон

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний  
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ц.Төмөрбаатар, Д.Ёндондаш нарыг сонгон томилсугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

0121074



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 54


Номгон


“Баянхонгор-Эрчим хүч” цахилгаан түгээх  
ХХК-ний дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Баянхонгор-Эрчим хүч” цахилгаан түгээх хязгаарлагдмал хариуцлагатай компаний дүрэм”-ийн 7.4.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Баянхонгор-Эрчим хүч” цахилгаан түгээх ХХК-ний дүрмийн 8.4-т заасан “Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байна” гэснийг “Төлөөлөн удирдах зөвлөл нь 11 гишүүнтэй байна” гэж өөрчлөлт оруулсугай.

2. Тогтоолын санд өөрчлөлт оруулж, холбогдох байгууллагад мэдэгдэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



0121103



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 136

Номгон

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний  
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс Л.Доржхандыг чөлөөлж, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн Г.Баатартогтохыг оруулсугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ

0121282